



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2022/8/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот

2022 оны 03 дугаар сар

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: myangnboom@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа
Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.	6
3.1 Компанийн үйл ажиллагаа	6
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	7
4. Аудитын тайлан	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Дотоод хяналт.....	11
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
4.4 Материаллаг байдал.....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	12
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Төлбөрийн акт.....	13
8.2 Албан шаардлага	14
8.3 Зөвлөмж.....	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101

Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.03.15 № 2/151

“БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ
ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Н.БАЯРСАЙХАН ТАНАА

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн,
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээлийг хугацаанд нь бүрэн төлүүлэх арга хэмжээ аваагүй,
- Нярав бараа материалын тайланг бэлтгээгүй байхад нягтлан бодогч нягтлан бодох бүртгэлд тусгасан,

• 005020676

- Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулаагүй, аудитаар өгсөн шилэн дансны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зээлийн эргэн төлөлтийн орлого болон захирлын хөрөнгө захиран зарцуулах тухай тушаалуудыг байршуулаагүй,
- Өмнөх оны авлага, өглөгийг барагдуул ажиллаагүй байна.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Тохиолдсон байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	121,713,998.12	282,019,662.10
1.1.02	Дансны авлага	43,158,107.47	17,478,317.67
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	57,341.44	55,000.00
1.1.04	Бусад авлага	2,038,650,632.37	1,888,059,611.52
1.1.06	Бараа материал	7,095,648.26	2,836,177.08
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,210,675,727.66	2,190,448,768.37
1.2.01	Үндсэн хөрөнгө	3,800,263,562.89	3,550,512,547.00
1.2.02	Биет бус хөрөнгө	111,210,000.00	111,210,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,911,473,562.89	3,661,722,547.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,122,149,290.55	5,852,171,315.37
2.1.1.01	Дансны өглөг	16,716,983.80	-
2.1.1.02	Цалингийн өглөг	62,169.00	61,372.50
2.1.1.03	Татварын өр	7,131,697.22	23,347,581.72
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	53,998.93
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	2,219,644,493.60	2,196,380,448.88
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	155,280.00	155,280.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,243,710,623.62	2,219,998,682.03
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,243,710,623.62	2,219,998,682.03
2.3.01	Өмч: - төрийн	4,220,427,922.36	4,220,427,922.36
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	111,759,000.00	111,759,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(453,748,255.43)	(700,014,289.02)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(246,266,033.59)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(453,748,255.43)	(453,748,255.43)
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,878,438,666.93	3,632,172,633.34
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,122,149,290.55	5,852,171,315.37

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант хугацааны дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	93,147,036.37	105,925,929.49
2	Борлуулалтын өртөг	297,909,074.59	285,355,345.77
3	Нийт ашиг(алдагдал)	(204,762,038.22)	(179,429,416.28)
4	Ерөнхий ба удирдлагын зардал	44,831,994.62	118,149,394.77
5	Зардлын дүн	44,831,994.62	118,149,394.77
6	Бусад ашиг (алдагдал)	84,566,701.12	51,312,777.46
7	Олз, гарзын дүн	84,566,701.12	51,312,777.46
8	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(165,027,331.72)	(246,266,033.59)
9	Татварын дараах ашиг (алдагдал)	(165,027,331.72)	(246,266,033.59)
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(165,027,331.72)	(246,266,033.59)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн Өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг/алдагдал	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	2,987,661,127.36	111,759,000.00	(290,120,923.71)	2,809,299,203.65
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	1,400,000.00	1,400,000.00
3	Залруулсан үлдэгдэл	2,987,661,127.36	111,759,000.00	(288,720,923.71)	2,810,699,203.65
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(165,027,331.72)	(165,027,331.72)
5	Өмчид гарсан өөрчлөлт	1,232,766,795.00	-	-	1,232,766,795.00
6	2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	4,220,427,922.36	111,759,000.00	(453,748,255.43)	3,878,438,666.93
7	Залруулсан үлдэгдэл	4,220,427,922.36	111,759,000.00	(453,748,255.43)	3,878,438,666.93
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(246,266,033.59)	(246,266,033.59)
9	2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	4,220,427,922.36	111,759,000.00	(700,014,289.02)	3,632,172,633.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,210,139,772.07	740,644,260.49
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	110,841,844.89	156,185,691.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	417,480,000.00	50,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	681,817,927.18	534,458,569.49
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,167,001,583.86	580,338,596.51
1.2.1	Ажиллагчдад төлсөн	68,361,810.00	90,825,644.75
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	23,805,027.93	29,116,313.15
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	43,182,627.00	12,729,227.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	39,183,066.33	3,776,471.78
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,117,605.00	4,017,180.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	6,438,867.40	12,410,523.15
1.2.9	Бусад мөнгөн зарлага	972,912,580.20	427,463,236.68
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	43,138,188.21	160,305,663.98
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	43,138,188.21	160,305,663.98
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	78,575,809.91	121,713,998.12
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	121,713,998.12	282,019,662.10

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Зардлын нэр	2020 оны гүйцэтгэл	2021 оны төлөвлөгөө	2021 оны гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин	93,007,115	109,250,000	110,431,965	(1,181,965)
2	ЭМД, НДШ	23,805,000	13,656,250	15,419,944	(1,763,694)
3	/татвар/		12,311,601	500,000	11,811,601
4	Цахилгааны зардал	12,523,083	15,605,504	1,301,065	14,304,439
5	Нүүрсний зардал /тээврийн зардалтай/	4,488,600	6,084,000	13,937,974	(7,853,974)
6	Халаалт	21,322,571	30,404,409	-	30,404,409
7	Цэвэр бохир усны зардал	1,139,347	1,985,016	247,682	1,737,334
8	Засвар үйлчилгээ ХӨ зардал	-	4,982,000	-	4,982,000
9	Элэгдлийн зардал	180,132,751	165,159,729	233,609,581	(68,449,852)
10	Ариутгал цэвэрлэгээ	2,035,134	2,042,200	2,372,083	(329,883)
11	Гамшгийн нөөцийн зардал	-	755,500	775,898	(20,398)
12	БГАҮ /бусдаар гүйцгүүлсэн ажил үйлчилгээ/	947,526	950,000	73,340	876,660
13	Хөдөлмөр хамгаалал	1,112,416	1,263,400	646,881	616,519
14	Бичиг хэрэг	1,469,126	2,191,000	2,615,292	(424,292)
15	Шуудан холбоо	1,089,943	1,200,000	1,262,392	(62,392)
16	Шатахуун	2,049,689	2,400,000	3,236,107	(836,107)
17	Урсгал засвар	976,131	300,000	2,510,742	(2,210,742)
18	Сэлбэгийн зардал	727,124	800,000	1,214,673	(414,673)
19	Бусад	30,011,100	3,053,000	6,584,026	(3,531,026)
20	ТУЗ урамшуулал	2,891,331	3,480,000	1,335,000	2,145,000
21	Албан томилолт	-	539,000	2,706,000	(2,167,000)
22	Шагнал, урамшуулал тэтгэмж	2,140,000	800,000		800,000
23	Зар сурталчилгаа	-	50,000	765,000	(715,000)
24	хог тээвэр		-	600,000	(600,000)
25	газрын төлбөр			429,095	(429,095)
26	сургалтын зардал		-	930,000	(930,000)
	Үйл ажиллагааны дүн	381,867,986	379,262,609	403,504,740	(24,242,131)

3. Санхүүгийн тайлангийн тодруулга.

3.1 Компанийн үйл ажиллагаа

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн зорилго нь “Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратеги бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бизнесийн орчныг дэмжих замаар зах зээлийг өргөжүүлэн, ажлын байрыг нэмэгдүүлэх”-д оршино.

Тус байгууллага гүйцэтгэх захирал, захиргаа хүний нөөцийн албаны 3, бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны албаны 3, үйлчилгээний 8, нийт 15 албан хаагчтай үйл ажиллагаа явуулж, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг сургах, хөгжүүлэх дэмжлэг үзүүлэх, холбон зуучлах, удирдлага арга зүйгээр ханган ажилладаг байна.

Тайлант онд аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран бизнесийн өмнөх, дараах сургалтыг зохион байгуулж, нийт 180 гаруй иргэн хамрагдсан, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хөдөө аж ахуйн газар, Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран 21 сумдын 111 жижиг үйлдвэрлэгчдийг оролцуулсан үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тус компанийг аймгийн ИТХ-ын Хуралдааны 2016.10.11-ний өдрийн тогтоолоор байгуулсан ба байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” гэсэн статустай, өмчийн 100 хувийг орон нутгийн өмч эзэмшиж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасан ба тогтоолыг зөрчсөн асуудал байхгүй байна.

Тус компани нь тайлант онд 217,816.0 мянган төгрөгийн орлого оруулж, 379,262.6 мянган төгрөгийн зардалтай төсөв батлагдсан ба үүнээс 165,159.7 мянган төгрөг нь элэгдлийн зардал байгаа ба тайлант онд 246,266.0 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1.1.01	Мөнгөн хөрөнгө	121,714.0	282,019.7	(160,305.7)
	Авлага	2,087,542.9	1,905,592.9	181,950.0
1.1.06	Бараа материал	7,095.6	2,836.2	4,259.5
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,210,675.7	2,190,448.8	20,227.0
1.2.01	Үндсэн хөрөнгө	3,800,263.6	3,550,512.5	249,751.0
1.2.02	Биет бус хөрөнгө	111,210.0	111,210.0	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,911,473.6	3,661,722.5	249,751.0
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,122,149.3	5,852,171.3	269,978.0
	Өр төлбөр	24,065.9	23,618.0	447.9
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	2,219,644.5	2,196,380.4	23,264.0
2.2	Өр төлбөрийн дүн	2,243,710.6	2,219,998.7	23,711.9
2.03.01	Өмч- төрийн	4,220,427.9	4,220,427.9	-

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.03.08	Эздийн өмчийн бусад хэсэг	111,759.0	111,759.0	-
2.03.09	Хуримтлагдсан ашиг	(453,748.3)	(700,014.3)	246,266.0
2.03.09.1	Тайлангийн үеийн алдагдал	-	(246,266.0)	246,266.0
2.3.09.2	Өмнөх үеийн алдагдал	(453,748.3)	(453,748.3)	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,878,438.7	3,632,172.6	246,266.0
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	6,122,149.3	5,852,171.3	269,978.0

Эх сурвалж: “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс нь мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөрийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 282,019.7 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 160,305.7 мянган төгрөгөөр өссөн ба үүнээс 857.6 мянган төгрөг нь кассын үлдэгдэл, 281,162.1 мянган төгрөг нь арилжаан банк дахь 5 дансны үлдэгдэл байна.

Арилжааны банкны харилцах дансны үлдэгдлийн 64.9 хувь буюу 182,359.6 мянган төгрөг нь Хас банк дахь зээлийн эргэн төлөлтийн орлого төвлөрүүлдэг дансны үлдэгдэл байна.

Хүснэгт 2. Арилжааны банкны харилцах дансны үлдэгдэл /мянган төгрөгөөр/

№	Банкны нэр	Дансны дугаар	2021 оны 12 -р сарын 31-нээрх үлдэгдэл	тайлбар
1	Төрийн банк	232100579428	33,244.44	Ахуй үйлчилгээний төвийн түрээс орлого төвлөрдөг
2	Хас банк-2	5002495853	42,077.22	Зээлийн хяналтын зардлын 5% хувь төвлөрдөг.
3	Хас банк-1	5002108778	182,359.58	Зээлийн эргэн төлөлт төвлөрдөг
4	Хаан банк	5249263063	22,154.22	Ажилсаг төвийн түрээсийн орлого төвлөрдөг
5	Голомт банк	6105103438	1,326.63	Ажилсаг төвийн түрээс орлого төвлөрдөг
	Дүн		281,162.10	

Эх сурвалж: “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн санхүүгийн тайлан, арилжааны банкны үлдэгдлийн баталгаа

Авлага дансны үлдэгдэл 1,905,592.9 мянган төгрөг болж 181,950.0 мянган төгрөгөөр буурсан нь зээлийн эргэн төлөлт багасаж, зээлийн авлага 150,591.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой ба үүнээс 1,887,633.8 мянган төгрөг нь 134 зээлдэгчтэй холбоотой зээлийн авлага байна.

Түрээслэгч нараас авах түрээсийн төлбөрийн авлага оны эхэнд 43,158.1 мянган төгрөг байсан бол оны эцэст авлага буурч, 17,478.3 мянган төгрөгийн авлагатай гарсан ба үүнээс 9,424.3 мянган төгрөг нь Ажилсаг төвийн 6 түрээслэгчтэй холбоотой, 8,054.0 мянган төгрөг нь ахуйн үйлчилгээний төвийн 4 түрээслэгчтэй холбоотой авлага бөгөөд эдгээр түрээслэгчдийг шүүхэд шилжүүлж, шүүхийн шийдвэр гарч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, зарим түрээслэгч нарын зээлд ажиллагаа хийгдэж эхэлсэн байна.

Авлагын эхний үлдэгдлээр байгаа 225.9 мянган төгрөг нь өмнө нь ажиллаж байсан Оюундэлгэртэй холбоотой авлага бөгөөд одоог хүртэл барагдаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,836.2 мянган төгрөг болж 4,259.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээр байсан нүүрсийг тайлант онд зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө нэмэгдээгүй, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2021.04.01-ний өдрийн 52 дугаар тогтоолоор “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2018 оны 290 дүгээр захирамжаар эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй олгосон иргэн Б.Отгонбилэгийн боловсруулсан зорилтот бүлгийн 30 өрхийн амьжиргааг дэмжих буцалтгүй олгосон 50,000.0 мянган төгрөгийн төслөөс бий болгосон

16,141.4 мянган төгрөгийн өртөг бүхий гүний худгийг тус корпорацаас аймгийн Орон нутгийн өмчийн газарт балансаас баланст шилжүүлсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 23,618.0 мянган төгрөг болж 447.9 мянган төгрөгөөр буурсан ба оны эцсийн өглөгийн 23,347.6 мянган төгрөг нь татварын өглөг бөгөөд оны эцэст татварыг төлж, өглөггүй ажиллах бүрэн боломжтой байсан ба өмнөх оны цалингийн өглөгийн 62.1 мянга, ажиллагсадтай холбоотой 85.3 мянга, хувь хүмүүст өгөх 70.0 мянга, нийт 217.4 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 3,632.2 мянган төгрөг болж 246,266.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдал байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Компанийн захирлаар ахлуулсан 4 албан хаагч 2021 оны бизнес төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны борлуулалтын орлогыг 217,816.0 мянга, үйл ажиллагааны бус орлогыг 11,125.0 мянга, нийт 228,941.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 384,322.6 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр борлуулалтын орлогыг 60,368.9 мянган төгрөгөөр тасарч, 157,447.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 398,074.6 мянган төгрөгийн зардал гаргаснаас 223,609.6 мянган төгрөг нь элэгдлийн зардал байна. Төлөвлөсөн зардлыг хэтрүүлсэн нь бизнес төлөвлөгөөнд элэгдлийн зардлыг 165,159.7 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 233,609.6 мянган төгрөг гарч, зардал анх төлөвлөснөөс 68,449.9 мянган төгрөгөөр хэтэрсэн нь 2020 оны 10 дугаар сард ахуйн үйлчилгээний төвийг хөрөнгөд бүртгэснээр элэгдлийн зардал өмнөх он болон бизнес төлөвлөгөөнд тусгаснаас өндөр гарсан, өмнөх оноос нярвын орон тоог нэмж, 3 ажилтны цалинг 50.0-250.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн зэрэгтэй холбоотой байна.

Тайлант онд оруулахаар төлөвлөсөн орлогоос төсөл боловсруулсны орлогыг 21.1 мянган төгрөгөөр давуулсан бөгөөд нийт орлогын гүйцэтгэл 157,447.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 60,368.9 мянган төгрөг буюу 27.7 хувиар тасарсан нь аймгаас олгох түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийн санхүүгийн дэмжлэгээр 80,000.0 мянган төгрөг батлагдсанаас 30,000.0 мянган төгрөгийг дутуу олгосон, бусад орлогоор 13,200.0 мянган төгрөгийн орлого оруулахаас нэг ч төгрөгийн орлого оруулаагүй, Ажилсаг төвийн түрээсийн орлогыг төлөвлөснөөс 3,352.6 мянга, Ахуйн үйлчилгээний төвийн түрээсийн орлогыг 13837.4 мянган төгрөгөөр дутуу оруулсан зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 3. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Төсөл хөтөлбөр боловсруулах	1,500	1,521	(21.2)	101.41
2	Ажилсаг төв	67,427	3,352.6	(,353)	95.03
	Ахуйн үйлчилгээний төв	55,689	13,837.5	(13,837)	75.15
	Түрээсийн хөнгөлөлт	80,000	30,000.0	(30,000)	62.50
3	Бусад	13,200	13,200.0	(13,200)	-
Борлуулалтын дүн		217,816	157,447	60,368.9	72.28

Эх сурвалж: Компанийн 2021 оны санхүүгийн тайлан

Нийт зардлын гүйцэтгэл 403,504.7 мянган төгрөг буюу төлөвлөснөөс 24,242.1 мянган төгрөгөөр зардлыг хэтрүүлэн 106.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тус компанийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

"Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 4. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин /мянган төгрөг/

№	Зардлын нэр	2020 оны гүйцэтгэл	2021 оны төлөвлөгөө	2021 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин	93,007.1	109,250.0	110,432.0	(1,182.0)	101.08
2	ЭМД, НДШ	23,805.0	13,656.3	15,419.9	(1,763.7)	112.91
3	/татвар/	-	12,311.6	500.0	11,811.6	4.06
4	Цахилгааны зардал	12,523.1	15,605.5	1,301.1	14,304.4	8.34
5	Нүүрсний зардал /тээврийн зардалтай/	4,488.6	6,084.0	13,938.0	(7,854.0)	229.09
6	Халаалт	21,322.6	30,404.4	-	30,404.4	-
7	Цэвэр бохир усны зардал	1,139.3	1,985.0	247.7	1,737.3	12.48
8	Засвар үйлчилгээ ХӨ зардал	-	4,982.0	-	4,982.0	-
9	Элэгдлийн зардал	180,132.8	165,159.7	233,609.6	(68,449.9)	141.44
10	Ариутгал цэвэрлэгээ	2,035.1	2,042.2	2,372.1	(329.9)	116.15
11	Гамшгийн нөөцийн зардал	-	755.5	775.9	(20.4)	102.70
12	БГАҮ /бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ/	947.5	950.0	73.3	876.7	7.72
13	Хөдөлмөр хамгаалал	1,112.4	1,263.4	646.9	616.5	51.20
14	Бичиг хэрэг	1,469.1	2,191.0	2,615.3	(424.3)	119.37
15	Шуудан холбоо	1,089.9	1,200.0	1,262.4	(62.4)	105.20
16	Шатахуун	2,049.7	2,400.0	3,236.1	(836.1)	134.84
17	Урсгал засвар	976.1	300.0	2,510.7	(2,210.7)	836.91
18	Сэлбэгийн зардал	727.1	800.0	1,214.7	(414.7)	151.83
19	Бусад	30,011.1	3,053.0	6,584.0	(3,531.0)	215.66
20	ТУЗ урамшуулал	2,891.3	3,480.0	1,335.0	2,145.0	38.36
21	Албан томилолт	-	539.0	2,706.0	(2,167.0)	502.04
22	Шагнал, урамшуулал тэтгэмж	2,140.0	800.0	-	800.0	-
23	Зар сурталчилгаа	-	50.0	765.0	(715.0)	1,530.00
24	хог тээвэр	-	-	600.0	(600.0)	0
25	газрын төлбөр	-	-	429.1	(429.1)	-
26	сургалтын зардал	-	-	930.0	(930.0)	-
	Үйл ажиллагааны дүн	381,868.0	379,262.6	403,504.7	(24,242.1)	106.39

Эх сурвалж: "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-ийн 2021 оны орлого, зардлын төлөвлөгөө

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Н.Баярсайхан танд танилцуулж байна

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зээлийн мэдээллийг Монгол банкны нэгдсэн мэдээллийн санд холбох арга замыг судлах, бизнес төлөвлөгөөнд зээлийн орлогыг тусгах, “Төгс төгөлдөр үйлс” ХХК-д бизнесийн арга зүйн туслалцаа үзүүлж, зээлийн асуудлыг орон нутгийн удирдлагуудад тавьж ойрын хугацаанд шийдвэрлэх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн тул цаашид Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Төрийн аудитын газарт санхүүгийн тайлан, холбогдох баримт материалыг шаардуулахгүй өгөх талаар компанийн удирдлага анхаарах шаардлагатай байна.

Тайлант жилд хөрөнгө зарцуулах нэгдүгээр гарын үсгийг Н.Баярсайхан, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч А.Одгэрэл нар зурсан байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Олон улсын стандарт дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодогчоор ажиллаж байсан Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч В.Наранцэцэг боловсруулж, компанийн захирлын 2017.06.28 өдрийн 05 дугаар тушаалаар баталж, одоог хүртэл мөрдөж ажиллаж байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Их” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 342,741.1 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 6,854.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 4,455.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 401,350,389 төгрөгөөс

2 хувиар буюу 8,027.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 65 хувиар тооцоход 5,217.5 мянган төгрөг байгаа тул, материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д өмнөх оны аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулах зөвлөмжийг өгсөн байхад мэдээлбэл зохих 144 мэдээллээс 47 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 397,267.8 мянган төгрөгийн 21 гүйлгээ, 2,414.0 мянган төгрөгийг зарцуулах тухай компанийн захирлын 2021 оны 18,19,27 дугаар тушаалуудыг мэдээлгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 397,267.8 мянган төгрөгийн 21 зарлагын гүйлгээ, захирлын тушаалуудыг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь дутуу, хугацаа хоцроосон мэдээлэл их, өмнөх оны аудитын зөвлөмжийн биелүүлээгүй тул Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж үзлээ.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд тус компанид санхүүгийн тайлангийн аудитаар 228,10.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосноос 3,350.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй ба 2 зөвлөмж өгснөөс Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн аудитаар 8 зээлдэгчтэй холбоотой 430,000.0 мянга, анхаарах асуудлын хүрээнд шалгасан аудитаар 44 түрээслэгчтэй холбоотой 28,373.9 мянган төгрөгийн албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн байна.

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 5.Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт /мянган төгрөг/

Зөрчлийн ангилал	Үзүүлэлт	Санхүүгийн тайлангийн аудитаар	Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"	Анхаарах асуудлын хүрээнд шалгасан аудитаар	Нийт
Төлбөрийн акт	Актын тоо	1	0		1
	Хүний тоо	44			44
	Тогтоосон	228,103.72	0		228,103.72
	Биелсэн/ төлсөн мөнгөн дүн/	78,120.42	0		78,120.42
	Биелсэн /хууль хяналтын байгууллага руу шилжүүлсэн/	146,633.30			146,633.30
	Биелээгүй	3,350.00	-	-	3,350.00
Албан шаардлага	Тоо		1	1	2
	Хүний тоо		8	24	32
	Өгсөн		430,000.00	28,373.99	458,373.99
	Биелсэн/ төлсөн мөнгөн дүн/		25,000.00	14,468.65	39,468.65
	Биелсэн /хууль хяналтын байгууллага руу шилжүүлсэн/		280,000.00	13,905.34	293,905.34
	Биелээгүй		125,000.00	-	125,000.00
Зөвлөмж	Тоо	2			2
	Өгсөн	26,994.40			26,994.40
	Биелсэн	26,994.40			26,994.40
	Биелээгүй -Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй	-	-	-	0
Нийт	Тоо	3	1	1	5
	Өгсөн	255,098.12	430,000.00	28,373.99	713,472.11
	Биелсэн	105,114.82	280,000.00	13,905.34	399,020.16
	Биелээгүй	3,350.00	125,000.00	-	128,350.00

Эх сурвалж: Шийдвэрийн биелэлт гаргасан хуудас, зээлийн мэдээлэл

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2020.12.21-ний өдрийн 125 дугаар тогтоолоор компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байхад компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг батлаагүй байгааг цаашид анхаарах нь зүйтэй байна.

Тайлант онд орон тооны нярвын орон тоотой болсон байхад нярав бараа материалын тайланг гаргаагүй байхад байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар хяналт тавиагүй алдаа илэрч, аудитын явцад няравт арга зүйн зөвлөгөө өгч, нярвын тайланг гаргуулан анхан шатны баримтад хавсаргасан болно.

Тус компанид төслийн ахлах болон менежер гэсэн 2 ажилтны ажлын байрны тодорхойлолтод бизнес эрхлэгчдэд төсөл бичсэний орлого оруулахаар заасан ба 2021 онд 1,500.0 мянган төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 26 төсөл бичиж, 1,521.1 мянган төгрөгийн орлого оруулсан нь тухайн ажилтнуудад олгосон цалингийн зардалтай харьцуулахад хангалтгүй үзүүлэлт гарч байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 484,017.7 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 82,413.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 399,681.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,922.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн материаллаг алдаа нь гүйцэтгэлийн шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгөв.

8.1 Төлбөрийн акт

1. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл авсан 23 иргэн, аж ахуйн нэгжид 82,069.7 мянган төгрөгийн зээлийг зээлийн гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хугацаа хэтрүүлсэн байхад арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлдэгчийн “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-тай байгуулсан жижиг, дунд үйлдвэрлэлийн дэмжих зээлийн гэрээний 5.2.2, 5.2.5 дахь заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоох.

2. Нягтлан бодогч 2021 оны 2 дугаар сард цалинг 2 хувааж олгохдоо хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 2 удаа тооцсон, амралтын цалинг цалингаас тусад нь бодохдоо татварын хөнгөлөлтийг 2 удаа тооцсоноос 15 ажилтанд 344.0 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоох.

8.2. Албан шаардлага

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д өмнөх оны аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулах зөвлөмжийг өгсөн байхад мэдээлбэл зохих 144 мэдээллээс 47 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 397,267.8 мянган төгрөгийн 21 гүйлгээ, 2,414.0 мянган төгрөгийг зарцуулах тухай компанийн захирлын 2021 оны 18,19,27 дугаар тушаалуудыг мэдээлгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 397,267.8 мянган төгрөгийн 21 зарлагын гүйлгээ, 6.4.8-д заасан захирлын тушаалуудыг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн төсвөөс аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийг олгож байсныг 2021 оноос хойш зогсоон, өмнөх онуудад олгосон зээлийн эргэн төлөлтийн орлогоос зээл олгох шийдвэр гаргасан ба тухайн онд орох зээлийн эргэн төлөлтийн орлого тодорхой байхад компанийн бизнес төлөвлөгөөнд зээлийн орлого, орлогоос олгох зээлийг төлөвлөдөггүй байна.

Өгсөн зөвлөмж: Зээлийн гэрээнд үндэслэн зээлийн эргэн төлөлтийн орлогыг ТУЗ-өөр баталж, зээлийн эргэн төлөлтийг тайлагнадаг байх.

2. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор олгосон хөнгөлөлттэй зээлээс хугацаа хэтрэлт их, хугацаа хэтэрсэн зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, шүүхийн шийдвэрээр эргэн төлөхөөр байхад зээлийн төлөлт хангалтгүй, 2021.12.31-ний өдрийн байдлаар 831,158.4 мянган төгрөгийн зээлд холбоотой 35 иргэн, аж ахуйн нэгжийн асуудал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шийдэгдэхээр шилжсэн байна.

Өгсөн зөвлөмж: Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор олгосон хөнгөлөлттэй зээлийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах асуудлыг судалж, санд мэдээллийг оруулах

3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөрөнгийн тооллогын бүртгэлд байгууллагад ажиллаж байсан хүний нэр дээр 1,478.9 мянган төгрөгийн цахилгаан үүсгүүр бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Цахилгаан үүсгүүрийн асуудлыг холбогдох албан тушаалтнуудаас тодруулан, нотлох баримтыг үндэслэн асуудлыг шийдвэрлэх

4. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Баянхонгор аймгийн Засаг даргын 2020.01.20-ний өдрийн А/20 дугаар захирамжаар “Төгс төгөлдөр үйлс” ХХК-д олгосон 280,000.0 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрч, Баянхонгор аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн шүүхийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021.12.20-ний өдрийн 131/ШЗ2021/02660 дугаар захирамжаар 2022.01.25-ний дотор зээлийг бүрэн төлөхөөр заасан боловч зээл төлөгдөөгүй байна. Тус зээлийн барьцаанд 3 ширхэг цахилгаанаар явдаг эко автобусыг авсан ба тус хөрөнгө ашиглалтгүй байна.

Өгсөн зөвлөмж: “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн захирал, төслийн менежерүүд “Төгс төгөлдөр үйлс” ХХК-д цаашид эко автобусуудыг хэрхэн ашиглаж үр өгөөж гаргах талаар бизнесийн тооцооллыг хийж, арга зүйн туслалцаа үзүүлж, орон нутгийн удирдлагуудад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

5. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх оны цалингийн өглөгийн 62.1 мянга, ажиллагсадтай холбоотой 85.3 мянга, хувь хүмүүст өгөх 70.0 мянга, нийт 217.4 мянган төгрөгийн өглөг, авлагын 225.9 мянган төгрөгийн эхний үлдэгдлийг барагдаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан дахь өмнөх оны авлага, өглөгийн эзэн холбогдогчийг тогтоон барагдуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл
A	1	3	4	5
Санхүүгийн тайлангийн асуудлаар				
1	Дансны үлдэгдэл	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл авсан 23 иргэн, аж ахуйн нэгжид 82,069.7 мянган төгрөгийн зээлийг зээлийн гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хугацаа хэтрүүлсэн байхад арга хэмжээ авч ажиллаагүй байна.	82,069,667.00	Төлбөрийн акт тогтоох
2	Орлоготой холбоотой асуудал	Орон нутгийн төсвөөс аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийг олгож байсныг 2021 оноос хойш зогсоон, өмнөх онуудад олгосон зээлийн эргэн төлөлтийн орлогоос зээл олгох шийдвэр гаргасан ба тухайн онд орох зээлийн эргэн төлөлтийн орлого тодорхой байхад компанийн бизнес төлөвлөгөөнд зээлийн орлого, орлогоос олгох зээлийг төлөвлөдөггүй байна.		Зөвлөмж өгөх
3	Дансны үлдэгдэл	Орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор олгосон хөнгөлөлттэй зээлээс хугацаа хэтрэлт их, хугацаа хэтэрсэн зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, шүүхийн шийдвэрээр эргэн төлөхөөр байхад зээлийн төлөлт хангалтгүй, 2021.12.31-ний өдрийн байдлаар 831,158.4 мянган төгрөгийн зээлд холбоотой 35 иргэн, аж ахуйн нэгжийн асуудал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шийдэгдэхээр шилжсэн байна.	0	Зөвлөмж өгөх
4	Дансны үлдэгдэл	Хөрөнгийн тооллогын бүртгэлд байгууллагад ажиллаж байсан хүний нэр дээр 1,478.9 мянган төгрөгийн цахилгаан үүсгүүр бүртгэлтэй байна.	1,478,940.0	Зөвлөмж өгөх

"Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл
5	Дансны үлдэгдэл	Баянхонгор аймгийн Засаг даргын 2020.01.20-ний өдрийн А/20 дугаар захирамжаар "Төгс төгөлдөр үйлс" ХХК-д олгосон 280,000.0 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрч, Баянхонгор аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн шүүхийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021.12.20-ний өдрийн 131/ШЗ2021/02660 дугаар захирамжаар 2022.01.25-ний дотор зээлийг бүрэн төлөхөөр заасан боловч зээл төлөгдөөгүй байна. Тус зээлийн барьцаанд 3 ширхэг цахилгаанаар явдаг эко автобусыг авсан ба тус хөрөнгө ашиглалтгүй байна.	-	Зөвлөмж өгөх
6	Дансны үлдэгдэл	Нягтлан бодогч 2021 оны 2 дугаар сард цалинг 2 хувааж олгохдоо хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 2 удаа тооцсон, амралтын цалинг цалингаас тусад нь бодохдоо татварын хөнгөлөлтийг 2 удаа тооцсоноос 15 ажилтанд 344.0 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү олгосон байна.	344,000.0	Төлбөрийн акт тогтоох
7	Дансны үлдэгдэл	Өмнөх оны цалингийн өглөгийн 62.1 мянга, ажиллагсадтай холбоотой 85.3 мянга, хувь хүмүүст өгөх 70.0 мянга, нийт 217.4 мянган төгрөгийн өглөг, авлагын 225.9 мянган төгрөгийн эхний үлдэгдлийг барагдаагүй байна.	443.300	Зөвлөмж өгөх
ДҮН			84,335,907	
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал				
1	Ажил гүйлгээний анги	"Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-д өмнөх оны аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулах зөвлөмжийг өгсөн байхад мэдээлбэл зохих 144 мэдээллээс 47 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 397,267.8 мянган төгрөгийн 21 гүйлгээ, 2,414.0 мянган төгрөгийг зарцуулах тухай компанийн захирлын 2021 оны 18,19,27 дугаар тушаалуудыг мэдээлгүй байна.	399,681,800.00	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй тул албан шаардлага өгөх
ДҮН			399,681,800.00	
НИЙТ АЛДААНЫ ДҮН			484,017.707.00	

---000---